

**АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-4

1. Байнгын хорооны даргыг сонгох тухай 3-4

**Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн бүрэн эрхийн анхдугаар чуулганы
Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны
2024 оны 7 дугаар сарын 10-ны өдөр /Лхагва/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 24 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр хуралдаан 06 цаг 28 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

Чөлөөтэй: О.Алтангэрэл, Э.Бат-Амгалан, Д.Ганбат, Б.Дэлгэрсайхан, Н.Наранбаатар, П.Наранбаяр, Н.Номтойбаяр, Б.Энхбаяр, С.Эрдэнэболд, Р.Эрдэнэбүрэн.

Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга М.Үнэнбат, мөн газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Хишигсүрэн нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлсэн талаар танилцуулав.

Нэр дэвшигчээс болон танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.

Д.Цогтбаатар: Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 14
Татгалзсан: 0
Бүгд: 14
100 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ч.Анар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 06 цаг 33 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 05 минут үргэлжилж, 24 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 58.3 хувийн ирцтэйгээр 06 цаг 33 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Д.ЦОГТБААТАР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Үндсэн хууль” танхим
06 цаг 28 минут.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Д.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүддээ энэ өглөөний мэндийг дэвшүүлье.

Ингээд Байнгын хорооны ирц бүрдсэн тул Байнгын хорооны 2024 оны 7 дугаар сарын 10-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Гишүүдийн ирцийг танилцуулъя.

Наранцэцэгийн Алтаншагай, Чинбатын Анар, Батын Батбаатар, Нацагдоржийн Батсүмбэрэл, Энхбатын Болормаа, Хажсекберийн Жангабыл, Батбаярын Жаргалан, Өлзийхүүгийн Шижир, Пүрэвжавын Сайнзориг, Ганзоригийн Тэмүүлэн, Ганбатын Хосбаяр, Дамдины Цогтбаатар, Жадамбын Энхбаяр, Лутын Энхнасан гэсэн ийм ирцтэйгээр өнөөдрийн хурлын ирц бүрдсэн байна. 58.3 хувиар ирц бүрдсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1.Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудал хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу?

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд алга байна. Тэгвэл асуудалдаа оръё. Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцье.

Ингээд Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Мөнхбаатар Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх талаар танилцуулга хийнэ. Мөнхбаатар даргын микрофоныг өгье.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн өглөөний мэнд хүргэе. Нэр дэвшүүлэх асуудлыг та бүхэнд танилцуулъя.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Ганзоригийн Тэмүүлэнг Гадаад бодлого тиймээ? Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байна. Ганзоригийн Тэмүүлэн гишүүний намтрыг та бүгдэд бас товч танилцуулъя.

2003 онд Америкийн Нэгдсэн Улсын Американ юниверсити сургуулийн Олон улсын харилцааны бакалавр, 2005 онд мөн сургуулийн Олон улсын удирдлагын магистр төгссөн.

2006 онд Ашигт малтмалын газрын тосны газрын Гэрээлэлтийн хэлтэст мэргэжилтэн

2007 онд Ашигт малтмал, газрын тосны газрын Гэрээлэлтийн хэлтэст ахлах мэргэжилтэн

2008-2009 онд Ашигт малтмал, газрын тосны газрын Гэрээлэлтийн хэлтсийн дарга

2009-2014 онд Төрийн өмчит “Эрдэнэс Монгол” компанид дэд захирал

2013-2015 онд Оюутолгой компанид ТУЗ-ийн гишүүн

2014-2015 онд Монгол Улсын Уул уурхай яамны дэд сайд

2015 оноос Нийгмийн ардчилал монголын залуучуудын холбооны ерөнхийлөгч

2015 оноос Монгол Ардын намын
Удирдах зөвлөлийн гишүүн

2016-2020 онд Монгол Улсын Их
Хурлын гишүүн

2020-2024 онд Монгол Улсын Их
Хурлын гишүүн

2022 оноос Монгол Улсын Их
Хурлын Төсвийн байнгын хороон дарга

2024 оноос Монгол Улсын Их
Хурлын гишүүнээр ажиллаж байна.

Ганзоригийн Тэмүүлэн гишүүний
төрд ажилласан туршлагыг үндэслэн
Байнгын хорооны даргад нэр дэвшүүлж
байна. Та бүхэн дэмжиж өгөхийг хүсье.

Д.Цогтбаатар: Мөнхбаатар
даргад баярлалаа. Ингээд Байнгын
хорооны даргад нэр дэвшүүлэх талаар
өөр саналтай гишүүд байна уу?

Алга байна.

Байнгын хорооны даргад нэр
дэвшигчээс асуух асуулттай гишүүд
байна уу?

Алга байна.

Тэгвэл Байнгын хорооны даргад
нэр дэвшиж байгаа гишүүнд хандаж үг
хэлэх гишүүд байна уу?

Алга байна.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Улсын Их Хурлын гишүүн
Ганзориг овогтой Тэмүүлэнг Аюулгүй
байдал, гадаад бодлогын байнгын
хорооны даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй
гэсэн томъёоллоор санал хураая. Саналаа
ил хурааж байгаа тээ? Саналаа ил
хураачихъя.

100 хувийн саналаар тэгвэл
дэмжигдэж байна.

100 хувийн саналаар дэмжигдлээ.
Санал хураалт 100 хувиар дэмжигдлээ.

Ингээд Байнгын хорооны даргад
нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцэж
дууслаа.

Байнгын хорооны санал,
дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд
Улсын Их Хурлын гишүүн Анар гишүүн
танилцуулчих уу? Тийм Их Хуралд ороод
юуг нь уншаад өгнө шүү дээ. Хэний Анар
билээ? Чинбаатарын? За Чинбаатарын
Анар. Анар гишүүн танилцуулна.

Хэлэлцэх асуудал дууссан тул
өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан
өндөрлөснийг мэдэгдье. Баярлалаа.

06.33 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР